

НҮБ –ЫН ХҮРЭЭН ДЭХ МОНГОЛ, ЯПОНЫ ХАРИЛЦААНЫ ЗАРИМ АСУУДАЛ

Н.Бадрал*

Дэлхийн хэмжээнд нэр алдраа гаргасан нэгэн чухал үйл явдал бол Монгол улс 1961 онд НҮБ-д элсэн орсноор дэлхийн хамтын нийгэмлэгт хууль ёсны байр сууриа эзлэх болсон байна. Монгол улс ийнхүү Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүнээр 1961 онд элсэн орсноос хойш 50 гаруй жилийг ардаа орхисон нь түүх болон үлджээ. Энэ нь Монгол Улсын Дипломат албаны түүхэнд чухал байр суурь эзлэх томоохон үйл явдал. Эдгээр он жилүүдэд Энэтхэг, Индонез, Египет зэрэг Ази, Африкийн шинэ тулгар тусгаар тогтносон олон улс Монголын ард түмний энэхүү хүсэл эрмэлзлэлийг ойлгож, олон улсын тавцан дээр идэвхтэй тууштай дэмжлэг үзүүлж байжээ. Монгол улс НҮБ-ын гишүүнд элсэхийн төлөө 1946 оноос эхлэн 1961 он хүртэл 15 жилийн туршид тэмцэж, энэ завсар 4 дахин өргөдөл гаргаж, Нэгдсэн Үндэстний Байгууллагаар нийтдээ 13 удаа хэлэлцэгдэж, ”...зарим хөрөнгөтөн орны эсэргүүцэлтэй тулгарч хойшилсоор ирсэн талаар түүхийн баримт, судалгааны бүтээлд тэмлэглэжээ¹. XX зууныг Монголчууд бидний сэргэн мандлын зуун хэмээн нэрлэдэг учир нь энэ зуунд туурга тусгаар, бүрэн эрхт төр улсаа байгуулж бэхжүүлсэн явдал хамгийн гол ололт. Монголчууд улс үндэстний хувьд сэргэн дэвжиж, дэлхийн бүрэн эрхт улс үндэстнүүдийн дунд нэр хүндтэй болсон явдал юм. Аливаа улс орны гадаад бодлого тухайн үеийн олон улсын харилцааны үйл явц, хөдлөл хувьсалтай салшгүй холбоотой.

Монгол Улсын гадаад, дотоод байдалд дэлхийн хоёр “халуун” дайн, нэг “хүйтэн” дайны үр уршиг амаргүй нөлөөлсөн” хэмээн проф. Л.Хайсандай бүтээлдээ тэмдэглэжээ.²

БНМАУ, Япон хоёр орны НҮБ-д элсэх бодлогод ямар хориг саад учирч ирсэн, түүнд их гүрнүүдийн нэн ялангуяа ЗХУ-ын гүйцэтгэсэн үүргийг харьцуулан хүрээнд гаргаж, улмаар НҮБ-ын гишүүнчлэлийн асуудалтай холбогдон дайны дараахи хоёр улсын харилцаа анх тус байгууллагын хүрээнд тавигдан эхэлсэнийг тухайн орнуудын гадаад дипломат бодлоготой холбон гаргахыг судлаачид зорьжээ.

”...НҮБ-ын хүрээнд дахь хоёр улсын хамтын ажиллагааг харуулахаасаа илүүтэй олон улсын энэхүү нэр хүндтэй байгууллагад хоёр өөр системд хамааралтай гэж үзэж ирсэн манай хоёр улс хэрхэн элсэхийг зорьсон, шинэ гишүүн орнуудыг элсүүлэх асуудал хэрхэн их гүрнүүдээс хамааралтай өрнөж байсныг онцгойлон авч үзжээ.

*МУИС, ОУХС-ийн багш, докторант

1. Нэгдсэн Үндэстний байгууллага ба Монгол улс. УБ.2008.х.3

2. Хайсандай Л. Олон улс судлалын өгүүлэлүүд. УБ.2003

Түүнчлэн энэхүү ижил төстэй өрнөсөн нөхцөл байдлын ерөнхий хүрээнд тус байгууллагын дотор анх хоёр улс бие биендээ ойртох, хамтран ажиллах эхлэл тавигдсаныг зарим нэгэн баримтаар нотлон харуулж, НҮБ дахь Монгол-Японы харилцааг 1946 оноос эхлүүлэн дипломат харилцаа тогтоосон тэр үеэр зааглан авч үзсэн билээ.³ Монгол, Япон хоёр улсын хувьд НҮБ-д элсэх хүсэлтээ БНМАУ 1946 оны 6 сард харин Япон нь 1952 оны 6 сард тус тус гаргасан нь дайны дараахи нөхцөл байдалтай шууд холбоотой. Монгол Улс 15 жил НҮБ-д элсэх тэмцлээ үргэлжлүүлсэн бол Япон нь 4 жилийн дотор асуудлаа шийдвэрлүүлсэн байдаг нь их гүрнүүдийн байр суурьтай шууд холбоотой ирсэн нь тодорхой гэж судлаачид үздэг.”... Монгол-Японы НҮБ-д элсэх асуудал нь, эдгээр улсын хувь заяа нь ЗХУ-ын гадаад бодлоготой шууд холбоотой байжээ. Япон нь 1955 онд дахин 2 дахь удаагаа хүсэлтээ сэргээж хандсан нь мөн амжилтгүй болсон...” 1956 оны 10 сарын 13 нд Москва хотноо Зөвлөлт-Японы хамтарсан тунхагийг байгуулсанаар хоёр сарын дараа Японы хүсэлтийг Оросын тал дэмжсэнээр НҮБ-ын гишүүн болсон байна.

Хэдийгээр Японы хувьд гишүүнчлэлийн асуудал харьцангуй богино хугацаанд шийдвэрлэгдсэн ч, түүнд ЗХУ, цаашилбал нөхөр В.М.Молотов ямар үүрэг гүйцэтгэж ирсэнийг судлаачид тодруулан үзэж зохих дүгнэлт гаргажээ.(Д.Наранцэцэг). НҮБ-ын эгнээнд элсэн орох олон улсуудын өргөдөл үндсэндээ хүйтэн дайны улмаас зогсонги байдалд орсон байдаг. Энэхүү гацаанаас гарах хэд хэдэн саналууд дараалан гарч байсны дотор хэд хэдэн улсыг нэгэн зэрэг элсүүлэх “Канадын төсөл” гэгч анхаарлыг татаж иржээ. Энэхүү төслийг АНУ, Англи, ЗХУ зэргийн их гүрнүүд эсэргүүцээр ирсэн бөгөөд нэн ялангуяа “...Чан Кай Шийн Хятад хэлэлцүүлэгийн явцад вето эрхийг хэрэглэсэнээр нэгэн зэрэг эдгээр улсуудыг элсүүлэх боломж хаагдсан”³ байдаг ажээ. Энэхүү үйл явдлын дараа ерөнхий сайд Ж. Неру НҮБ-ын гишүүн орнууд БНМАУ ба Японы тухайн байгууллагын гишүүн орон болох тэмүүлэлийг дэмжих хэрэгтэй хэмээн албан ёсоор мэдэгдсэн байдаг нь гишүүнчлэлийн асуудал хэр төвөгтэй шийдвэрлэгдэж ирсэний нэгэн тод жишээ юм. Монгол ба Япон хоёр улс нь НҮБ-ын гишүүн болох гэсэн тэмцэлдээ нэг нь Зөвлөлтийг баримжаалж, нөгөө нь АНУ-ыг дагалдаж байсан ч аль алинийхан хувьд “ хүйтэн дайны” бодлогын нөлөө шууд ул мөрөө үлдээж иржээ.

Ийнхүү 1955 оны хувьд Канадын 18 улсыг нэгэн зэрэг элсүүлэх төсөл, түүний араас Зөвлөлтийн санаачлагаар гаргасан хоёр төрлийн хувилбарт санал биелэлээ олж чадаагүй үлдсэн байдаг. 1955 оны 12 сарын 14-нд шийдэгдэж, Японы талд тавьсан болзолын дагуу дараахи жилийн 10 сарын 19-нд ЗХУ, Японы нэгдсэн тунхагын үндсэн дээр НҮБ-ын гишүүн болсон байдаг. Монгол улс олон саад бэрхшээлийг үл хайхран НҮБ-ын

3. Наранцэцэг Д. НҮБ дахь Монгол-Японы харилцаа (1946-72)

гишүүн болсноор дэлхийн улс орнуудаар өөрийн улсыг албан ёсоор хүлээн зөвшөөрүүлэх, олон улсын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох замаар цаашдын Монгол улсын хөгжлийн төлөө тууштай явж иржээ.

Монгол улс Зүүн Хойт Азийн /ЗХА/ бүс нутгийн улс орнуудтай улс төр, эдийн засгийн хувьд харилцан хамаарал ихтэй орон. Хойшид ч өөрийн орны цаашдын хөгжлийг хангахад энэ бүс нутгийн улс орнуудтай харилцан тэгш, харилцан ашигтай, нягт хамтран ажиллахыг чухалчилжээ. Монгол улс ЗХА-ийн бүс нутгийн аль ч улстай ямар нэгэн улс төр, газар нутаг, хилийн маргаангүй, энхийг эрхэмлэгч орон. Монгол улс бүс нутгийн асуудлыг хэлэлцэж байх механизмыг бий болгохын төлөө НҮБ-ын Ерөнхий Ассамблейн(2000) 55-р чуулганд санал оруулж байсан. Одоо ч энэ бүс нутгийн маргаантай асуудлыг яриа хэлэлцээний замаар шийдвэрлэхийн төлөө хүчин зүтгэж байгаа. “Зүүн Хойт Азийн орнуудын харилцаа улс төрийн гэхээсээ илүү эдийн засагжсан шинжийг агуулж байгаа. Монгол улсын гол хөрөнгө оруулагчид, худалдааны чухал түншүүд болох ОХУ, БНХАУ, Япон, БНСУ-тай хоёр талын шугамаар эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлж байна. Монгол, Хятад хоёр улс Зүүн Хойт Азийн бүс нутгийн орнуудтай зөвхөн хоёр талын худалдаа, эдийн засгийн харилцааг хөгжүүлж байгаа нь нийтлэг зүйл юм. Харин Зүүн Хойт Азийн бүс нутгийн хамтын ажиллагаанд Монгол улсын хувьд ялгаатай тал нь гэвэл тус бүс нутгийн ардчилсан улс болох Япон, Өмнөд Солонгос хоёр Монгол дахь ардчилалыг анхнаас нь дэмжиж эдийн засаг, боловсрол, хүмүүнлэгийн салбарт илүү хамтын ажиллагааг хөгжүүлэхийг эрмэлзэж байгаа болно. Япон улс Монголын ардчилал, шинэчлэлийг хоёр талын харилцааны хүрээнд болон олон улсын хэмжээнд дэмжин туслах бодлогыг 1991 онд зарлан тууштай хэрэгжүүлжээ. Зөвлөлтийн тусламж хумигдаж Монгол улс зах зээлд шилжих хүндхэн үеүүдэд Япон улс “их долоог” уриалан “донор” орон болж дэмжлэг тусламж үзүүлж байсан. Япон улс Монголыг Японы нийгэмд таниулах, Японыг монголчуудад таниулах талаар ихээхэн ажил зохиодог нь ард түмний талархал хүлээж ирлээ. Монгол Улсын Ерөнхийлөгч 1998 онд Япон улсад айлчлах үеэр гаргасан “Монгол улс, Япон улсын найрамдал хамтын ажиллагааны тухай хамтарсан мэдэгдэл”-д хоёр орны харилцааг иж бүрэн түншлэлийн хэмжээнд хөгжүүлэх зарчмыг тунхагласан. Эдүгээ хоёр орны харилцаа иж бүрэн түншлэлийн суурин дээр бүх салбарт өргөжин хөгжиж байна.

Эдүгээ Монгол Улс НҮБ-ийн төрөлжсөн олон улсын байгууллагуудын гишүүн болж, тэдгээртэй хамтран ажиллаж, хөгжлийн олон хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж, тэдгээр байгууллагаас үзүүлдэг тусламж дэмжлэгээс хүртэх болсноор илэрч байна. Монгол Улс НҮБ-д элсэн орсны дараагаар түүнийг Өрнөдийн гүрнүүд хүлээн зөвшөөрч, албан ёсны дипломат харилцаа тогтоох үйл явц өрнөсөн байна. Энэ нь бүтэн 15 жилийн

шургуу дипломат тэмцлийн үр дүнд бодит биелэлээ олсон хэмээн дүгнэн үзэх үндэстэй юм. Энэ талаар Элчин сайд Я.Ичихаши: "... Монгол Улс өнөөг хүртэл Япон улсыг НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн байнгын гишүүн орон болгох асуудлыг тууштай дэмжиж ирсэн. Мөн 2008 онд болох НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн байнгын бус гишүүн орны сонгуульд Япон улс нэрээ дэвшүүлэхийг дэмжихээр шийдвэрлэсэн нь "Найрсаг сайн санааны алхам". Энэ нь Солонгосын хойгийн асуудлаас эхлээд шийдвэрлэвэл зохих олон асуудал тулгараад байгаа өнөөгийн олон улсын нөхцөл байдалд НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн байнгын гишүүн орон болж, энэ зөвлөлд боломжийнхоо хэрээр хувь нэмрээ оруулахыг хүссэн Япон орны санаа бодлыг дэмжиж байгаагийн илрэл⁴ хэмээжээ.

Дэлхийн II дайны дараагаас өнөөг хүртэлх Монгол, Японы харилцааг судлаачид хэд хэдэн үед хуваан авч үзсэн байна. Эхний үе нь дайны дараах хоёр орон бие биеэ цоо шинээр танин мэдэх, түүхээс үлдсэн ээдрээтэй хэдэн асуудлын шийдлийг олох гэсэн үе байв. Дараах үе нь Монгол, Японы хооронд дипломат харилцаа тогтоох үйл явц. 1970-аад оны эхэн хүртэл сунжирсан явдал нь дайны төлбөр, Монголд байсан Японы олзны цэргүүдийн асуудал зэрэг маргаантай хэд хэдэн асуудлаас үүдэлтэй байжээ

1960-аад оноос 1972 он хүртэлх хоёр орны хооронд хэвийн, дипломат харилцаа тогтоосон улс төрийн түүх нь хоёр орны дотоод улс төрийн байдлаас гадна тухайн "хүйтэн дайн"-ны үеийн олон улсын байдал, Тайваний хүчин зүйл, АНУ-ын байр суурь, Япон, Зөвлөлт, Япон-Хятадын харилцаанаас хамаарч байсан. Япон улс, Монголыг олон улсын байгууллагын гишүүнд элсэхийг дэмжиж саналаа өгсөн нь Монгол улсын тусгаар тогтнолыг де-фактаар хүлээн зөвшөөрсөн хэрэг.

Монгол, Японы хооронд урт хугацааны турш яагаад дипломат харилцаа тогтоогоогүй нь учир нь нэг талаар Япон улс НҮБ-ыг төвчилж үзэх үзлийг гадаад харилцааны үндсэн бодлогоо болгон барьж ирсэн. Монголыг НҮБ-д гишүүнээр элссэнээс хойш 10 гаруй жилийн хугацаанд дипломат харилцаа тогтоогоогүй ирсэн шалтгаан нь тэр үеийн улс төрийн харилцаа, нэн ялангуяа Зүүн Европын хүйтэн дайн, Хятад, Зөвлөлт Холбоот Улсын сөргөлдөөн, эс бөгөөс ЗХУ, БНХАУ, Тайвань, Америк зэрэг төвөгтэй харилцаа нөлөөлж байсан. Дэлхийн II дайны дараа хоёр улсын хооронд ямар ч харилцаа байхгүй үе арваад жил үргэлжилжээ. 1961 онд Монгол Улс НҮБ-д гишүүнээр элссэн нь Монгол Улсын хувьд олон улсын байр сууриа дээшлүүлэхийн зэрэгцээ Япон, Монгол хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоох тухайд туйлын чухал ач холбогдолтой болсон. Гэвч хоёр улсын хооронд тодорхой улс төрийн үйл ажиллагаа тийм хурдан өрнөөгүй байна. 1963 онд төрийн бус "Жуулчлалын хамтын ажиллагааны гэрээ" байгуулагдсан ч мөн чанартаа жуулчны чиглэлээр ахиц дэвшил гараагүй. Ингээд 1966 онд Монгол дахь Япон цэргийн булшийг Японы Засгийн

4. Ясүёши Ичихаши: Би Монголд анх оюутан байхдаа ирж байлаа-//Өдрийн Сонин. 2007/04/25)

газраас очиж эргэх төлөөлөгчдийн группийг илгээжээ.

Энэ үйл явдал дипломат харилцаа тогтоох үйл явцад Монгол Улс НҮБ-д гишүүнээр элссэн явдлын дараа орохоор маш том алхам болсон гэж японы судлаачид үздэг. Ялангуяа Монголын тал энэхүү арга хэмжээг талархалтай хүлээн авсан нь Японы Засгийн газар, ард иргэдэд баяр хөөртэй сэтгэгдэл үлдээж, түүний дараа дараагийн харилцааг хурдасгахад чухал хүчин зүйл болсон ажээ. Энэхүү булш эргэх үйл ажиллагаа нь сонин хэвлэлүүдээр Монголыг танилцуулах тэр боломжийг буй болгон “Дипломат харилцааг хурдан хугацаанд тогтоох нь зүйтэй” гэсэн дүгнэлтийг олон нийтэд илэрхийлсэн байна. Олон сонин “дипломат харилцаа тогтоох” асуудлыг дэмжсэн нийтлэлүүдийг гаргаж, энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэхэд Япон, Монголын нийгэмлэг, нэн ялангуяа Монгол Улсаас Токио хотод нээгдсэн Ази-Африкийн зохиолчдын их хурал, Ази номхон далайн эдийн засгийн байгууллагын хурал/ECAFE/, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын хурал /ILO/ зэрэг янз бүрийн боломж нөхцлийг ашиглаж Японд төлөөлөгчдөө илгээж ирсэн бөгөөд Монголын талаас төлөөлөгчдийн түвшинг аажим аажим өндөрсгөсөөр ирсэн байна. Японоос ч 1969 онд олон намын бүрэлдэхүүнтэй парламентын гишүүдийн төлөөлөгчид айлчилж, Сайд нарын зөвлөлийн орлогч дарга Д.Гомбожав гуайн айлчлалд хариу барьж 1971 онд Японы Засгийн газрын албан ёсны төлөөлөгчид Монголд айлчилж, дипломат харилцаа тогтоох асуудлыг үндсэндээ бодитой болгож, түүнийгээ улс орны дотоод, гадаад нөхцөл бүрэлдэж хэрэгжүүлэхээр тогтжээ. 1971 онд Японоос Улаан Загалмайн нийгэмлэгээр дамжуулан Монголд эрүүл мэндийн тусламж болгож 20 мянган доллартай тэнцэх түргэн тусламжийн машин, донорын нүүдлийн машин зэрэг хэрэгслийг бэлэглэжээ. БНМАУ, Япон улсын хооронд дипломат харилцаа тогтоосон тухай хамтарсан албан мэдээнд: “БНМАУ, Япон улсын хооронд дипломат харилцаа тогтоож Элчин сайдын хэмжээнд дипломат төлөөлөгч солилцохоор хоёр улсын Засгийн газар шийдвэрлэжээ. БНМАУ, Япон улсын хооронд дипломат харилцаа тогтоосон нь хоёр орны эдийн засаг, соёлын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд тус дөхөм болно гэдэгт итгэж байгаагаа хоёр тал илэрхийлэв”⁵. Ингээд 1972 оны 2 дугаар сарын 24-ны өдөр Монгол, Японы хооронд дипломат харилцаа тогтоосныг харилцан батламжилж хоёр тал “Нот” солилцжээ.

Японы талын онцлог гэвэл хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоох, харилцааг хөгжүүлэхэд эсэргүүцэх хүчин байгааг үйд оршиж байна. Энэ цаг мөчөөс тус хоёр улс дипломат харилцаа тогтоох сонирхолоо илэрхийлж, уулзалт яриа эхэлсэн боловч Японы тал Халх голын дайн, Дэлхийн II дайны улмаас Монголд учруулсан хохирлыг төлөх учиргүй гэж маргасны учир 11 жил хойшилж эцэст нь 1972 оны 2 сарын 24-нд дипломат харилцаа тогтоож дайны төлбөр нэрээр биш эдийн засгийн тусламжийн хэлбэрээр Японы Засгийн Газар Монголд хөрөнгө олгох болсон байна

5. МУ-ын ГХтөв архив

хэмээн судалгааны зарим баримт бичигт тэмдэглэсэн байна.

XXI зуун гарсаар хоёр орны харилцаа дээд, өндөр түвшний яриа хэлэлцээний давтамж нэмэгдэж, агуулга өргөжиж, 1997 оноос хойш Япон улстай хөгжүүлсэн иж бүрэн түншлэлийн харилцааг шат ахиулж, “Стратегийн түншлэл”-ийн түвшинд хөгжүүлэхээр 2010 онд тохиролцсон нь түүхэн чухал алхам болсон юм. Стратегийн түншлэлийн гол үндэс нь хоёр улсын хоорондын эдийн засаг, хөрөнгө оруулалтын урт хугацааны тогтвортой хамтын ажиллагааны суурь болж өгөх таван баганаас бүрдэж буй юм. **Нэгдүгээрт**, улс төрийн салбарт харилцан бие биенээ сайн ойлгож, итгэмжилсэн харилцааг хөгжүүлж, бэхжүүлэх учиртай. **Хоёрдугаарт**, бие биедээ харилцан ашигтай, нэгнийгээ нөхсөн эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлнэ. **Гуравдугаарт**, бүс нутгийн болоод олон улсын тавцанд хамтарч ажиллана. **Дөрөвдүгээрт**, соёл, боловсрол, спорт, урлаг, олон нийтийн байгууллагуудын хэмжээнд иргэдийн солилцоог идэвхжүүлэх. **Тавдугаарт**, олон улсын глобал асуудлууд, НҮБ-ын хүрээнд хамтран ажиллаж, бие биенээ дэмжих учиртай⁶. Түүнчлэн, 2011 онд УИХ-аас баталсан “Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал” баримт бичигт⁷ дурдсанаар Монгол Улсын Улс төрийн гадаад харилцааны бодлогын зорилго нь ①ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь гадаад харилцааны бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд тэдгээр улстай бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хүрээтэй хамтын ажиллагаа хөгжүүлнэ. Чингэхдээ энэ хоёр улстай харилцаж ирсэн түүхэн уламжлал, эдийн засгийн хамтын ажиллагааны өвөрмөц онцлогийг харгалзах; ② АНУ, Япон, Европын холбоо, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг өрнө, дорнын улс, холбоотой “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх; ③ Азийн бусад улстай хоёр талын найрсаг харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх, Ази, Номхон далайн бүс нутагт олон талт хамтын ажиллагаанд оролцох, Зүүн Ази, Зүүн хойд Ази, Төв Азид стратегийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, аюулгүй байдлын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг дэмжиж оролцох; ④ Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн байгууллагууд болон олон улсын санхүү, худалдаа, эдийн засгийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа идэвхтэй үргэлжлүүлэх, дэлхийн засаглал дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэхийг дэмжиж ажиллах; ⑤ Хөгжиж байгаа улсуудтай хоёр талын харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэхийн зэрэгцээ Нэгдсэн Үндэстний Байгууллага, “77”-гийн бүлэг, Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн зэрэг олон талын хүрээнд хамтран ажиллах. Түүнчлэн, Улс төрийн гадаад харилцааны бодлогын чиглэлүүдийг харгалзан тус улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын байршлыг тогтоож,

6. Хүрэлбаатар С: Японтой экспортын зээлийн шугам нээх гэрээ байгуулна.. MongolNews.mn. 2012

7. Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал”-баримт бичиг.УБ.2011

гадаад бодлогыг хэрэгжүүлэх нөхцөлийг сайжруулах, хөгжлийн эрэлт хэрэгцээ, үндэсний аюулгүй байдлыг хангах зорилтод нийцсэн гадаад бодлогын судалгаа, шинжилгээ, гадаад харилцааны мэргэшсэн хүний нөөцийн бэлтгэл, сургалтын тогтолцоо бүрдүүлнэ...” хэмээн баримт бичигт тэмдэглэсэн. Энэхүү баримт бичигт Монгол-Японы харилцааны ойрын таван жилийн үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон байна.

Япон улсын Ерөнхий сайд Ш.Абэ сэтгүүлчдэд хандаж хэлэхдээ “Өнгөрөгч гуравдугаар сард Монгол Улсад айлчлах үеэр дэвшүүлсэн миний санаачилгыг дэмжсэний үр дүнд ийнхүү дунд хугацааны хөтөлбөрөө баталж байна. Өнөөдөр баталсан хамтын ажиллагааны дунд хугацааны хөтөлбөрийг тогтмол хэрэгжүүлснээр хоёр орны стратегийн түншлэлийн хамтын ажиллагаа улам бүр батжина гэдэгт итгэлтэй байна” гэсэн байна. Харин Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг “Монгол, Япон хоёр улс Стратегийн түншлэлийн түвшинд 2013-2017 онд хамтран ажиллах хөтөлбөр, төлөвлөгөөгөө баталсан энэ удаагийн айлчлалын гол үр дүн» хэмээн тодорхойллоо.

Эцэст нь дүгнэж үзвэл, Монгол, Японы дипломат харилцааг хөгжлийн хэд хэдэн үе шат болгон авч үзэх боломжтой. Учир нь шат тус бүр хоёр орны тухайн үеийн нийгэм, улс төр, эдийн засгийн байдлаас үүдээд өөр өөрийн онцлог бүхий хөгжлийн чиг хандлагтай байна. Хоёр орны харилцааг “Иж бүрэн түншлэл”-ээс “Стратегийн түншлэл” болгож хөгжүүлэхэд түүнд нийцсэн харилцааг бий болгоход ялангуяа эдийн засгийн салбар дахь харилцааг улам бүр бэхжүүлэхэд хүчин чармайлт гаргах нь бодит зүйл болж байгааг хамтын үйл ажиллагаа харуулж ирлээ. Стратегийн түншлэлийн харилцаанд шилжин орсноор хоёр орны хоорондын худалдаа, эдийн засгийн харилцааг гүнзгийрүүлэх, Япон Улсын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, улмаар Монгол, Япон хоёр улс олон улсын глобал асуудлууд, НҮБ-ын хүрээнд хамтран ажиллаж бие биенээ дэмжих өргөн боломж бүрдсэн хэмээн үзэх үндэслэлтэй.

Ашигласан номзүй:

1. Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал”-баримт бичиг.УБ.2011
2. Монгол Улсын ГХтөв архив
3. Наранцэцэг Д.НҮБ дахь Монгол-Японы харилцаа(1946-72)
4. Нэгдсэн Үндэстний байгууллага ба Монгол улс. УБ.2008. х.3
5. Хайсандай Л.Олон улс судлалын өгүүлэлүүд.УБ.2003.
6. Хүрэлбаатар С: Японтой экспортын зээлийн шугам нээх гэрээ байгуулна- MongolNews.mn. 2012
7. Ясүёши Ичихаши: Би Монголд анх оюутан байхдаа ирж байлаа-// Өдрийн Сонин. 2007/04/25)